

13

МОНГОЛЫН АРИЛЖААНЫ БАНКУУД БА ТӨВ БАНКНЫ ХЯНАЛТ

П.Оюунбилэг

Зах зээлийн эдийн засагт манай орон шилжсэнээр банк – санхүүгийн тогтолцоонд өөрчлөлт гарч ардчиллын эхний үеүдэд төрийн өмчийн оролцоотой ба хувийн банкууд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулах болсон юм. Одоо манайд 15 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна.

Банкны тухай хуулинд зааснаар манай арилжааны банкууд дүрмийн сангийн өмчлөлөөр төрийн, хувийн болон холимог; үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат; банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нийтлэг ба төрөлжсөн байж болно. Харин олон улсын практикт өмчийн хэлбэрээр улсын, хувийн, хоршооллын, хувь нийлүүлсэн, гадаадын; бүтцээр нь салбартай, салбаргүй; үйл ажиллагаагаар нь нийтлэг ба төрөлжсөн; үйлчлэх хүрээгээр нь хотын, орон нутгийн, мужийн гэх зэргээр ангилдаг. Олон улсын ангилалын дагуу банкуудын үйл ажиллагаагаа явуулж буй болон явуулж байсан хэлбэрээр нь авч үзвэл:

- Улсын арилжааны банкны гол үүрэг нь засгийн газрын төслийг хэрэгжүүлэх, засгийн газрын шугамаар олгогдож байгаа гадаад, дотоодын зээл тусламжийн хөрөнгийг байршуулах, эдийн засгийн хүнд нөхцөлд тодорхой салбар болон тулгамдсан асуудлуудыг санхүүжүүлэх зэрэг төрийн арилжааны банкны үүрэг гүйцэтгэдэг. Төрийн өмчийн ба төрийн өмчийн оролцоотой банк гэж байна. Манайд төрийн өмчийн 1, төрийн өмчийн оролцоотой 5 банк ажиллаж байна. Төрийн өмчийн Хадгаламжийн банкны хэлбэр нь хадгаламжийн хүүгээр зохицуулж мөнгөний нийлүүлэлтийг удирдахад сайн талтай боловч бусад арилжааны банкуудын хадгаламж хэлбэрээр хөрөнгө татах боломжийг хязгаарлаж байдгаараа сул талтай. Харин Хөдөө Аж Ахуйн банкны хувьд ихэнх оронд төрийн арилжааны банк байдаг уламжлалтай. Учир нь Хөдөө Аж Ахуй нь хүн амыг хүнсний зүйлээр, аж үйлдвэрийг түүхий эдээр хангаж байдаг. Манай Хөдөө Аж Ахуйн банк нь төрийн өмчийн оролцоотой банк юм. Энэ банк хэд хэдэн удаа төлбөрийн чадвар нь хүндэрч байсан боловч тухай бүрд нь Монгол банкнаас сэргээх арга хэмжээ авч

байжээ. 1999 онд Хөдөө Аж Ахуйн банкны алдагдлыг хувь нийлүүлэгчдийнх нь хөрөнгөөр хааж, гадаадын хөрөнгө оруулалт, засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагааг нь сэргээснээр одоо ХААН банкны санхүү, төлбөрийн чадвар эрс сайжирч, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт гэхэд Монголбанкны шаардлагын түвшнээс 2.5 дахин илүү байна. ХААН банкны үйл ажиллагаа хэвийн хэмжээнд явуулах бэлтгэл хангагдаад зээлийн бодлогоо тодорхойлон, эхний зээлүүдээ олгож эхлээд байна.

- Хувь нийлүүлсэн арилжааны банк нь компаниуд хувь хөрөнгөө нийлүүлж байгуулдаг банк юм. Монгол хоршоо, Монгол бизнес, Төв-Ази, Монгол Даатгал банкууд ийм байдлаар ажиллаж байгаад дампуурсан байна. Олон улсын практикт хувь нийлүүлэгчид нь тухайн банкны харилцагч байж болдоггүй зарчимтай байдаг. Гэтэл манай хувь нийлүүлсэн банкуудын хувьд харин ч эсрэгээр үйл ажиллагаагаа явуулж, хувь нийлүүлэгчид нь хамгийн их хэмжээний зээл авагч байдаг нь банкаа дампууруулахад хүргэсэн байна. Жишээлбэл: Монгол бизнес банкны хувь нийлүүлэгчид Соён ХХК нь банкны дүрмийн санд 114.5 сая төгрөг оруулсаны 46.6 хувь буюу 53.4 сая төгрөгийн зээлийг төлөөгүй, Женко ХХК дүрмийн санд 68.6 сая төгрөг оруулсаны 36.8 хувь буюу 25.3 сая төгрөгийн зээлийг төлөөгүй бол Кроун ХХК нь дүрмийн санд 60.3 сая төгрөг оруулсанаасаа 8.1 дахин их буюу 492.8 сая төгрөгийн зээлийг төлөөгүй байх жишээтэй. Төв-Ази банкны хувь нийлүүлэгч Гэмү ХХК нь дүрмийн санд оруулсанаасаа 31 дахин их, Монгол-Алтай ХХК 65 дахин их, Шүр ХХК 36 дахин их зээл авсан байжээ. Монгол Даатгал банкны хувь нийлүүлэгч Сувд Мөрөн ХХК 80 дахин их, Авдарбаян ХХК 110 дахин их гэх мэтээр тоочиж баршгүй тоо баримт гарч байна. Дээрх банкуудын татан буугдах үед чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь Монгол бизнес банк 93%, Төв-Ази банк 41%, Монгол Даатгал банк 69% байжээ.
- Хоршооллын арилжааны банк нь зөвхөн хөрөнгө хоршигчдийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг банк юм. Ийм банкны хоршигчид зээлээ төлөхгүй тохиолдолд өөрсдийн хөрөнгөө алдагдалд оруулдаг учраас хоршигчдийн хариуцлага, бие, биедээ тавих шаардлага, банкиндаа тавих хяналт илүү байдаг байна. Монгол Хоршоо банк нь анх ийм хэлбэрээр байгуулагдаж ажилласан боловч хувь нийлүүлсэн банкны зарчмаар ажилласнаас болж дампуурсан байна. Манай улсад хоршооллын банк байгуулах нь ийм өмчийн хэлбэрийн жижиг дунд аж ахуй үлэмжхэн байдагтай холбоотойгоор ихээхэн ач холбогдолтой нь тодорхой. Манай орны хувьд жижиг дунд аж ахуйн нэгжүүд хөрөнгө мөнгөөр гачигддаг, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай байдаг нь ийм хэлбэрийн банкыг зайлшгүй шаардах болсон байна. Хоршооллын банк нь хоршигчдийн хувь хөрөнгөөр байгуулагддаг учир зээл, зээлийн хүүг зохицуулах боломжтойгоороо давуутай юм.
- Хувийн банк нь нэг хүний хөрөнгөөр байгуулагдсан банк юм. Гэхдээ хөрөнгийн эзэн заавал банкыг удирдах албагүй, мэргэжлийн хүнийг авч удирдуулдаг байна. Хувийн банкны давуу тал нь зөвхөн өөрийнх нь хөрөнгө учраас хяналт өндөр, үйл ажиллагаа нь уян хатан байдаг. Манайд Голомт, Тээвэр хөгжил, Анод, Зоос зэрэг хувийн 9 банк ажиллаж байна.
- Төрөлжсөн арилжааны банк нь аль нэг салбар юмуу, үйл ажиллагааны чиглэлийг дагнан ажилладаг арилжааны банк болно. Ийм төрөлжсөн банкууд нь голдуу засгийн газрын харъяаны байдаг. Учир нь улсаас дэмжин хөгжүүлэх тодорхой салбар болон үйл ажиллагааг энэ чиглэлээр төрөлжсөн банкаар дамжуулан явуулбал үр дүнтэй байдгийг бусад орны туршлага харуулж байна. Манайд төрөлжсөн банк байгуулагдаж байгаагүй. Харин улс орон зах зээлд шилжсэнтэй уялдаж төрөлжсөн банк байгуулах шаардлага тавигдаж байна. Тодорхой салбар, үйл ажиллагааг дэмжих, мөн дотоод, гадаадын зээл тусламжийг төрөлжсөн банкаар дамжуулан олговол хүүний хөнгөлөлт, зориулалт зэргийг хянах бололцоотой болно. Төрөлжсөн банк үгүйгээс дээрх зээл тусламж бусад арилжааны банкаар дамжин олгогддог нь зээлийн хүү өсч, ямар ч судалгаа, шинжилгээгүйгээр дээрээс нэр заасан газарт зээл олгосноос зээлийн эрсдлийг өндөрсгөн, хөрөнгө эзэнгүйдэхэд хүрч байгаа дутагдал үлэмжхэн хэмжээгээр гарч байгаа юм.

- Нийтлэг арилжааны банк нь банкны олон төрлийн үйлчилгээг нэгэн зэрэг явуулах үйл ажиллагаа эрхэлдэг. Манайд ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа арилжааны банкууд нь нийтлэг үйл ажиллагаа явуулдаг бөгөөд харилцагчдад өргөн боломж олгодог, зарим төрлийн үйл ажиллагааны алдагдлыг өөр үйл ажиллагаанаас нөхөх боломжтой, банкны ажилтнууд олон чиглэлээр ажиллаж сурдаг зэрэг давуу талтай боловч удирдлага зохион байгуулалт нь нүсэр, техник ашиглах боломж муу, ажилтнуудын сургалтын зардал өндөр зэрэг дутагдал илэрдэг.
- Салбартай арилжааны банкны давуу тал нь хөрөнгө татан төвлөрүүлэхэд байдаг. Манай улсад 1990-ээд онд салбартай арилжааны банкууд давамгайлж байсан бол тэдгээр нь төлбөрийн чадвараа алдсанаас одоо салбаргүй банкууд давамгайлах болжээ. Гэвч зарим арилжааны банкууд салбараа байгуулахыг нэлээд чухалчлан үздэг болоод байна. Манай арилжааны банкуудаас 2000 оны байдлаар ХААН банк 17, Монгол шуудан банк 21, Худалдаа хөгжлийн банк 9, Хадгаламж банк 7, Шинэчлэл банк 3, Эрэл банк 3, Тээвэр хөгжлийн банк 2, Зоос банк 3, Голомт банк 1, салбартайгаар үйл ажиллагаа явуулах болж үйлчилгээний хүрээ нь тэлж байна.
- Салбаргүй арилжааны банкны давуу тал буюу онцлог нь тэдгээрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх гол үндэс болж байна. Бусад орнуудын практикаас харахад тухайн орон өөрийн онцлог болон бодлогоосоо хамааран аль бүтцийг нь илүү хөгжүүлэхээ хуулиараа тогтоон зохицуулж өгдөг байна. Жишээлбэл: АНУ-д салбаргүй арилжааны банк давамгайлж байдаг бол Японд салбартай арилжааны банкыг давамгайлсан хөгжүүлдэг байх жишээтэй.

Арилжааны банкууд өөрийн шинж чанараас хамаарч үндсэн зорилгоо тодорхойлдог. Хувийн банкуудын гол зорилго нь өндөр ашиг олоход чиглэгддэг байхад хоршооллын банк нь хоршигчдийнхоо ашиг сонирхлыг хангах, хадгаламжийн банк нь хадгаламж эзэмшигчдийн хадгалуулсан мөнгийг эрсдлээс хамгаалах зэрэг өөр өөрийн өвөрмөц зорилготой байна.

Хэдийгээр арилжааны банкуудын зорилго үйлчлүүлэгчдээсээ хамаарч өөр өөр байх боловч банкны салбарын хувьд нийтлэг хэд хэдэн зорилготой байна. Эдгээр нийтлэг зорилго нь:

- Ашиг олох.
- Төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх чадвартай байх.
- Өөрийн хөрөнгийг тогтвортой, хэвийн хэмжээнд байлгах.
- Нэр хүндтэй байх.
- Өрсөлдөх чадвартай байх.
- Хүнээ хөгжүүлэх, ажилтнуудынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн эх үүсвэртэй байх зэрэг юм.

Өнгөц харахад дээрх зорилго нь банкны ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байдлыг үүсгэдэг боловч үйл ажиллагааны эцсийн үр дүнгээр ашгийг нэмэгдүүлэх замаар ашигт ажиллагааг дээшлүүлдэг болно. Жишээлбэл: банкны байгууллага төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангахын тулд өөрийн хөрөнгийнхөө нэлээд хэсгийг үнэт цаасанд байршуулбал түүний хүү нь бага байдгаас ашгийг нэмэгдүүлэхэд төдий л үр ашигтай арга биш боловч банкны нэр хүндийг өндөр байлгахад нийцэх жишээтэй юм.

Дээрх нийтлэг зорилгыг хангуулах болон ер нь банкны системийг тогтвортой байлгах үүднээс Арилжааны банкуудын үйл ажиллагааг Төв банк хянаж байдаг. Ингэж хянаж байх менежментийн чиг үүрэг банкны хуулинд ч тусгагджээ. Төв банкнаас арилжааны банкуудад хяналт тавих дараахи үндэслэлүүд байгаа юм.

- Арилжааны банкин дахь хадгаламж, харилцах дансаа иргэд тэр бүр очиж шалгаад байдаггүй. Иймд энэ хяналтын үүргийг төр өөртөө авч хадгалуулагчдын хөрөнгийг алдагдлаас хамгаалж байх;

- Арилжааны банкны бизнесийн хөрөнгийн гол эх үүсвэр бусдын мөнгө байдаг. Энэ хөрөнгийг хамгаалахын тулд Төв банк хяналтын үүрэг гүйцэтгэдэг;
- Арилжааны банкаар дамжиж улсын хэмжээний төлбөр тооцоо хийгддэг. Хэрэв арилжааны банкуудын төлбөрийн чадвар алдагдвал улс орны эдийн засаг хүндрэх аюултай.
- Төв банк нь мөнгө-зээлийн бодлогоо арилжааны банкуудаар дамжуулан хэрэгжүүлдэг.
- Нэг арилжааны банк дампуурвал банкинд итгэх итгэл буурч банкны системийн хямрал гарах тул нэг ч банкныг дампууруулахгүй байхын тулд Төв банк ажиллах ёстой.

Төв банкнаас арилжааны банкуудад хяналт тавих олон арга байдаг боловч хамгийн гол арга нь банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоож мөрдүүлэх явдал мөн. Монгол банкнаас арилжааны банкуудад тогтоож хяналт тавьдаг шалгуур үзүүлэлтүүд:

- Өөрийн хөрөнгийн харьцаа
- I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа
- Заавал байлгах нөөцийн хангалт
- Чанаргүй зээлийн нийт зээлийн өөрийн үлдэгдэлд эзлэх хувь
- Нэг зээлдэгчид олгох зээлийн үзүүлэлтийн биелэлт
- Холбогдох этгээдэд олгосон зээлийн үзүүлэлтийн биелэлт
- Зээлийн эрсдлийн сангийн хүрэлцээ
- Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт юм.

Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн зарим тооцоолол болон арилжааны банкууд хэрхэн хангаж байгааг судалгаагаар харуулбал:

1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Өөрийн хөрөнгийн хүрэлцээг тодорхойлсноор тухайн банк активынхаа хэдэн хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа, банк алдагдалд орвол алдагдлын хэдэн хувийг өөрийн хөрөнгөөр нөхөн барагдуулах чадвартайг мэдэж болно. Өөрийн хөрөнгийн харьцааг тооцохдоо нийт өөрийн хөрөнгийн дүнг цэвэршүүлсэн активын нийт дүнд хуваана. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлт нь нийт өөрийн хөрөнгийн хувьд 10 хувиас, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 5 хувиас доошгүй байх хэмжээг мөрдөж байна.

2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (ТТГЧ)

ТТГЧ-ын харьцааг тооцоноор тухайн банк нь хадгаламж эзэмшигч, харилцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын анхны шаардлагаар төлбөрийг түргэн гүйцэтгэж чадах эсэхийг харж болно. ТТГЧ-ын үзүүлэлтийг тооцохдоо түргэн борлогдох активыг бусдаас татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн дүнд харьцуулж тооцох ба ТТГЧ-ын шалгуур үзүүлэлтийг бусдаас татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийн 18 хувиас доошгүй түвшинд байлгана.

Эдгээр харьцаануудыг банкууд сар, улирал, жилийн тайлан тэнцэлдээ үндэслэн үнэн зөв тооцож байх явдал нь тухайн банкны цаашдын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг тооцох, сэргийлэх ач холбогдолтой. Эдгээр харьцаануудыг тооцох аргачлалыг Голомт банкны 1999 оны 12 сарын 31-ний баланс дээр судалж харуулав.

1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцох

	I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд	Дансууд	Үлдэгдэл
1	Дүрмийн сан /ердийн хувьцаа/	3101	2071699.8
2	Нөөцийн сан	3103	
3	Тухайн жилийн ашиг	3106	268775.5
4	Өнгөрсөн жилийн ашиг	3108	137812.0

I зэрэглэлийн өөрийн хөрөнгө = (1+2+3+4-5-6-7-8-9-10-11)
Голомт банкны I зэрэглэлийн өөрийн хөрөнгө = 2 478 287.3 сая төгрөг.

	II зэрэглэлийн өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд	Дансууд
12	Дүрмийн сан /давуу эрхтэй хувьцаа/	3102
13	Дахин үнэлгээний сан	3105
14	Хоёрдогч өглөг /5-аас дээш жилийн хугацаатай/	3106

II зэрэглэлийн өөрийн хөрөнгө = (12+13+14)
Нийт өөрийн хөрөнгө = I зэрэглэлийн өөрийн хөрөнгө + II зэрэглэлийн өөрийн хөрөнгө
Голомт банкны нийт өөрийн хөрөнгө = 2 478 287.3 сая төгрөг.

	Активын үзүүлэлт	Дансууд	Үлдэгдэл	Эрсдэлийн түвшин	Эрсдэл тооцсон
1	Мөнгөн хөрөнгө	1101-106, 1111, 1113	1131518.0	0%	0
2	МБ дахь харилцах, хадгаламж	1107, 1108, 1116, 1117	365784.0	0%	0
3	Дотоодын банкуудаас авах авлага (1 жилээс доош хугацаатай)	1114, 1115, 1118, 1119	372571.5	20%	74514.3
5	ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын банкин дахь харилцах	1110	216741.4	20%	433408.3
6	ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын банкин дахь нэг жилээс доош хугацаатай хадгаламж	1112	774835.2	20%	1549647
8	Зээлийн өөрийн үлдэгдэл	1201-1283, 1286-1296	8553290	100%	8553290
9	Монгол банкны үнэт цаас	1301, 1311	1170000	0%	0
10	Засгийн газрын үнэт цаас (1 жилээс доош хугацаатай)	1303.1313	2108555	20%	421711
13	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	1401	43864	100%	43864
14	Үндсэн хөрөнгө	1501-1504	1935152	100%	193552

Активын дүн = (1+2+3+4+5+6+7+8+9+10+11+12+13+14+15)
Голомт банкны активын дүн = 14 172 288 сая төгрөг

Тэнцлийн гадуурхи дансны дүнд орох үзүүлэлтүүд:

16. Гадаад худалдааны аккредитивууд
- | | | | |
|-----------------------------------------|------------|--------|---------|
| а) Гадаад худалдааны аккредитивууд | 9905, 9906 | 156820 | 156 820 |
| б) Харилцагчийн аккредитивийн эх үүсвэр | 2304 | | |
17. Хүлээж болзошгүй үүргүүд 9901-9904

Тэнцлийн гадуурхи дансны дүн = (16-17)
Голомт банкны тэнцлийн гадуурхи дансны дүн = 156 820
Нийт цэвэршүүлсэн актив = активын дүн + тэнцлийн гадуурхи дансны дүн
Голомт банкны нийт цэвэршүүлсэн актив = 14 329 108 сая төгрөг
I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа = (I зэрэглэлийн өөрийн хөрөнгө/нийт цэвэршүүлсэн актив) * 100 %
Голомт банкны I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа = 17%
Өөрийн хөрөнгийн харьцаа = (нийт өөрийн хөрөнгө/нийт цэвэршүүлсэн актив) * 100 %
Голомт банкны нийт өөрийн хөрөнгийн харьцаа = 17%

2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тооцох

1) Түргэн борлогдох активт:	
1. Мөнгөн хөрөнгө	1 131 518
2. Монгол банкин дахь харилцах, хадгаламж	3 665 194
3. Монгол банкны үнэт цаас	1 170 000
4. Бусад банкин дахь харилцах, хадгаламж (1110, 1112, 1114, 1115, 1118, 1119)	10 287 84

Түргэн борлогдох актив (ТБА) = (1+2+3+4)

Голомт банкны ТБА = 16 254 558 сая төгрөг

2) Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд орох үзүүлэлтүүд:

1	Харилцах	2101-2119, 2120-2139, 2140-2151, 2160-2163, 2406, 2408, 2415	8522106
2	Бүх төрлийн хадгаламж	а) 2201-2219, 2220-2239, 2280-2283, 2290-2293, 2407, 2409, 2416	5320307
		б) 2240-2259, 2260-2277, 2285-2288, 2295-2298, 2407, 2409, 2416	13468731
3	Зарим эх үүсвэр	2301-2305, 2315, 2320, 2321, 2412, 2413	305708
7	Гадаадын банкнаас татсан зарим эх үүсвэр	2417, 2419, 2426	915184
8	Бусад пассив	2503-2560	8349432

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө (БТТХ) = (1+2+3+4+5+6+7+8)

Голомт банкны БТТХ = 36 881 468 сая төгрөг

ТТГЧ - ын харьцаа = (ТБА / БТТХ) * 100 % Голомт банкны ТТГЧ = 44% Эндээс үзэхэд 1999 оны эцсийн байдлаар Голомт банкны ТТГЧ хангалттай байсан байна.

3. Заавал байлгах нөөц

Арилжааны банкны заавал байлгах нөөц нь иргэд, харилцагчдын харилцах данс, хадгаламжийн үлдэгдэл болон Монголбанкнаас тогтоосон банкны бусад пассивын дүнгийн 14 хувиас багагүй байна. Банкны бэлэн нөөц нь тухайн банкны кассад байгаа бэлэн мөнгө ба Монгол банкин дахь харилцах дансны үлдэгдлийн хэлбэрээр байж болно.

4. Зээлийн багцын чанар

Нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байна. Банкны гишүүн, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, банкны гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон тэдгээрт холбогдох этгээдэд олгох зээлийн дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй байна.

5. Зээлийн эрсдлийн сангийн хүрэлцээ

Зээлийн эрсдлийн санг байгуулахдаа зээлийн ангилал тус бүрийн үлдэгдлээс дараахь хувь хэмжээг баримтлан тооцож байгуулна.

1. Хэвийн зээл	өрийн үлдэгдлийн 1%
2. Чанаргүй зээл. Үүнээс:	
а. Хугацаа хэтэрсэн зээл	өрийн үлдэгдлийн 1%
б. Хэвийн бус зээл	өрийн үлдэгдлийн 25%
в. Эргэлзээтэй зээл	өрийн үлдэгдлийн 50%
г. Муу зээл	өрийн үлдэгдлийн 100%

6. Гадаад валютын ханшийн эрсдлийн

Гадаад валютыг зохистой байршуулах нь валютын ханшийн өөрчлөлтөөс гарах алдагдлаас урьдчилан сэргийлэхэд орших бөгөөд энэ үзүүлэлтэд гадаад актив, пассивын зөрүү нь нийт валютын хувьд өөрийн хөрөнгийн +/- 20 хувиас, тухайн нэг валютын хувьд +/- 10 хувиас тус тус хэтрэхгүй байна.

Голомт банкны хувьд судалгааг тодорхой тооцооны хэлбэрээр авч үзлээ. Бусад арилжааны банкуудын хувьд Монгол банкнаас тогтоож өгдөг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож үзэхэд дараахь үр дүн харагдаж байна.

Хүснэгт №4

Банкуудын зохистой харьцааны үзүүлэлтүүдийн хангалтын судалгаа (2000. 06.31 байдлаар)

Банкуудын нэр	Өөрийн хөрөнгийн харьцаа (хувь)	I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа (хувь)	ТТГЧ-ын харьцаа (хувь)	Заавал байлгах нөөцийн хангалт	Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	Нэг зээлдэгчид олгох зээлийн үзүүлэлтийн биелэлт (20%)	Холбогдох этгээдэд олгосон зээлийн үзүүлэлтийн биелэлт (20%)	Холбогдох этгээдэд олгосон зээлийн үзүүлэлтийн биелэлт (5%)	Зээлийн сангийн эрсдлийн хүрэлцээ	Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт (+/- 20%)
Худалдаа хөгжил	31.2	22.2	74.7	+	34.8	+	+	+	+	77.1
Хадгаламж	6.5	6.4	23	+	29.2	+	+	+	+	8.4
Голомт	16.2	16.2	56	+	16.7	+	-	-	+	7
Монгол шуудан	21	21	46.3	+	42.2	+	-	-	+	12
Эрэл	72.6	72.6	21	+	0	+	+	+	+	-2.6
Улаанбаатар	34.3	34.3	56.3	+	6.1	+	+	+	+	-8.8
Шинэчлэл	34.5	21.5	-17	-	94.4	+	+	-	+	23.4
Тээвэр хөгжил	61.3	61.3	34.2	+	14.3	+	+	+	+	10.1
Кредит	111.8	111.8	125.1	+	8.5	+	+	-	+	5.7
Зоос	58.1	58.1	31.7	+	3.7	+	+	+	+	6.2
Анод	38.8	38.8	59.5	+	6.3	+	+	+	+	9.1

Дээрхи судалгаанаас харахад:

- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтийг Хадгаламж банкнаас бусад банкууд биелүүлж байгаа ба нэлээд хэдэн банкинд энэ үзүүлэлт өндөр байгаа нь ихэнх банк эрсдлийнхээ зохих хэсгийг өөрийн хөрөнгөөрөө нөхөж чадахаар байгааг харуулж байна.
- Шинэчлэл банкнаас бусад банкууд ТТГЧ-ын үзүүлэлт сайн байгаа нь банкны системийн төлбөрийн чадвар дээшилснийг илэрхийлж байна.
- Заавал байлгах нөөцийн хүрэлцээ Шинэчлэл банкнаас бусад банкинд сайн байна.
- Банкны системийн хувьд чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 29.17 хувь байгаа нь их тоо биш боловч зарим банк Шинэчлэл банк 94.4%, Худалдаа хөгжлийн банк 34.8%, Монгол шуудан банк 42.2% байгаа нь анхаарууштай асуудалд тооцогдож байна.
- Банкны гишүүд, удирдлага, холбогдох этгээдэд олгосон зээлийн дээд хэмжээг нэлээд олон банк зөрчсөн байгаа нь өөрсдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийхгүй байгааг харуулж байна.

Энэ судалгаа бол арилжааны банкуудын үйл ажиллагаа нэлээд хэмжээгээр сайжирсан урьд нь дампуурч үйл ажиллагаагаа зогсоосон банкнаас хойшхи үе бөгөөд арилжааны банкууд дампуурсанд дүгнэлт хийж зохион байгуулалтын арга хэмжээ авсан, арилжааны банкууд ч өөрсдийн үйл ажиллагаанд дүгнэлт хийх болсон үе юм.

№	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага	Хүний нөөцийн удирдлага
1	+	+	+	+	+	+	+	+	+	+
2	+	+	+	+	+	+	+	+	+	+
3	+	+	+	+	+	+	+	+	+	+
4	+	+	+	+	+	+	+	+	+	+
5	+	+	+	+	+	+	+	+	+	+
6	+	+	+	+	+	+	+	+	+	+
7	+	+	+	+	+	+	+	+	+	+
8	+	+	+	+	+	+	+	+	+	+
9	+	+	+	+	+	+	+	+	+	+
10	+	+	+	+	+	+	+	+	+	+
11	+	+	+	+	+	+	+	+	+	+
12	+	+	+	+	+	+	+	+	+	+
13	+	+	+	+	+	+	+	+	+	+
14	+	+	+	+	+	+	+	+	+	+
15	+	+	+	+	+	+	+	+	+	+
16	+	+	+	+	+	+	+	+	+	+
17	+	+	+	+	+	+	+	+	+	+
18	+	+	+	+	+	+	+	+	+	+
19	+	+	+	+	+	+	+	+	+	+
20	+	+	+	+	+	+	+	+	+	+
21	+	+	+	+	+	+	+	+	+	+
22	+	+	+	+	+	+	+	+	+	+
23	+	+	+	+	+	+	+	+	+	+
24	+	+	+	+	+	+	+	+	+	+
25	+	+	+	+	+	+	+	+	+	+
26	+	+	+	+	+	+	+	+	+	+
27	+	+	+	+	+	+	+	+	+	+
28	+	+	+	+	+	+	+	+	+	+
29	+	+	+	+	+	+	+	+	+	+
30	+	+	+	+	+	+	+	+	+	+
31	+	+	+	+	+	+	+	+	+	+
32	+	+	+	+	+	+	+	+	+	+
33	+	+	+	+	+	+	+	+	+	+
34	+	+	+	+	+	+	+	+	+	+
35	+	+	+	+	+	+	+	+	+	+
36	+	+	+	+	+	+	+	+	+	+
37	+	+	+	+	+	+	+	+	+	+
38	+	+	+	+	+	+	+	+	+	+
39	+	+	+	+	+	+	+	+	+	+
40	+	+	+	+	+	+	+	+	+	+
41	+	+	+	+	+	+	+	+	+	+
42	+	+	+	+	+	+	+	+	+	+
43	+	+	+	+	+	+	+	+	+	+
44	+	+	+	+	+	+	+	+	+	+
45	+	+	+	+	+	+	+	+	+	+
46	+	+	+	+	+	+	+	+	+	+
47	+	+	+	+	+	+	+	+	+	+
48	+	+	+	+	+	+	+	+	+	+
49	+	+	+	+	+	+	+	+	+	+
50	+	+	+	+	+	+	+	+	+	+

Танилцуулга

МУИС-ийн ЭЗС-ийн Менежментийн тэнхим

Тэнхимийн эрхлэгч: Доктор (Ph) Н.Сонинтамир
 Байршил: МУИС-ийн хичээлийн IV байр, өрөө 213, 214
 Утас: 351000

Тэнхимийн товч түүх

Тус тэнхим нь 1959 онд УААА-н эдийн засаг-төлөвлөлтийн тэнхим нэртэйгээр байгуулагдсан. 1988 онд Худалдааны эдийн засгийн тэнхимтэй нэгдэж салбарын эдийн засаг, төлөвлөлтийн тэнхим, 1990 оноос биеэ даасан Менежментийн тэнхим болон үйл ажиллагаагаа явуулж байна.

1991 оноос багш нарын атестатчилал явуулж бүрэлдэхүүнээ бэхжүүлсэн. Дэлхийн банктай хамтран "Макро эдийн засгийн менежмент" сэдвээр сургалт зохион байгуулж, багш нарынхаа зах зээлийн эдийн засаг, менежмент болон англи хэлний мэдлэгийг дээшлүүлсэн. Дараа нь эдийн засаг, менежментийн сургалт эрхэлдэг сургуулиудын консорциумын шугамаар менежментийн сургалт өөрчлөх төсөлд оролцож, сургалтын төлөвлөгөө хичээлийн агуулгаа шинэчилсэн юм.

Тус тэнхим Менежментийн онол, Үйлдвэрлэлийн ба үйл ажиллагааны менежмент, Аж үйлдвэрийн эдийн засаг, ХАА-н эдийн засаг, Хүний нөөцийн удирдлага, Байгууллагын зан төлөв, Удирдлагын шийдвэр, Монголын ба олон улсын эдийн засгийн орчин, Олон улсын менежмент, Монголын бизнесийн удирдлага, Стратегийн менежмент, Бизнес төлөвлөлт, Захиргааны менежмент зэрэг хичээлүүдийг эрхлэн заадаг. Одоогийн байдлаар тус тэнхим нь менежмент-бизнесийн удирдлага чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг. Тус тэнхимийг байгуулсан цагаас хойш дээр дурдсан мэргэжлээр 1200-аад хүн төгссөн.

Тус тэнхим нь сургалтын ажлын зэрэгцээ эрдэм шинжилгээний төсөлт ажлуудыг гүйцэтгэн, гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай санал зөвөлгөө солилцон хамтран ажилладаг. Одоогийн байдлаар "Макро эдийн засгийн менежмент, бүс нутгийн хөгжлийн төлөвлөлт, бизнес төлөвлөлт, стратегийн менежмент"-ийн чиглэлээр судалгааны ажил хийж байна.